

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД, ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАТАЙ БАЙГУУЛСАН ГЭРЭЭНД
ТУСГАГДСАН “БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БОДЛОГЫГ ОРОН НУТАГТ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА
ХЭМЖЭЭНИЙ 2022 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

2022.12.01

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Үр дүнгийн үзүүлэлт			
		Зарцуулсан хөрөнгө	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар)
1.”БАЙГАЛЬ ОРЧНЫ ХОЛБОГДОХ ХУУЛЬ, ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ” ЗААЛТЫН ХҮРЭЭНД					
1	2	3	4	5	6
1.1.	Байгалийн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах талаарх иргэд олон нийтийн мэдлэг, хандлагыг дээшлүүлэх сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулах	Бохнах-5.5 сая Зорилтот жилийн зардлаас-10.0 сая	-Орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ байгуулж ажилласан эсэх -Байгаль орчны хууль тогтоомжийг сурталчлах, сургалт, сурталчилгааны ажлын тоогоор -Тэмдэглэлт өдрүүдийн хүрээнд ажлын төлөвлөгөө гаргаж ажилласан байдал	20-иос доошгүй сургалт сурталчилгаа, эх бэлтгэл, постер-50, мэдээ сурвалжлага-35	-Байгаль орчны хууль, дүрэм, журам, стандарт, “Тэрбум” мод үндэсний хөдөлгөөний хүрээнд мод бут тарих ажлыг иргэдэд сурталчлах, мэдээ мэдээллийг олон нийтэд цаг алдалгүй хүргэх зорилгоор орон нутгийн “Соёмбо”, МҮОНР телевиз, ӨВ live.mn сайт, эх бэлтгэлийн “Оюу нана брэнд” ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулан, 78 эх бэлтгэл, сурталчилгааны постер, 32 удаагийн мэдээ, 4 сэдвийн сурвалжилга, 2 шторк, 5 шууд live нэвтрүүлгүүдийг хийлгэж аймгийн томоохон вэйб сайт болон байгууллагын пэйж хуудас, вэйб хуудсаар дамжуулан нийтэд сурталчиллаа. -Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх-Орчны бохирдлыг бууруулах зорилтот жил"-ийн хүрээнд иргэдэд мод, бут тарих, чиглэлээр 11 удаагийн сургалт, 2 уулзалт, 1 зөвлөгөөн зохион байгуулж 1300 орчим иргэд хамрагдсан. Байгалийн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах талаарх иргэд олон нийтийн мэдлэг, хандлагыг дээшлүүлэх сургалт, нөлөөллийн ажлыг 26 удаа зохион байгуулж, байгаль орчны тэмдэглэлт өдрүүдийн хүрээнд Арвайхээр сумын ерөнхий боловсролын Мэргэд, I, II, IV, V дугаар сургуулийн 8-12 ангийн сурагчдад аймгийн нэн ховор, ховор амьтан ургамлын талаар танин мэдэхүйн сургалтыг зохион байгуулж 500 гаруй сурагчид хамрагдаж, “Цоохор ирвэс хамгаалах” дэлхийн өдрийн хүрээнд тус газраас сургалт танин мэдэхүйн хичээл, гарын авлага бэлтгэж Арвайхээр,

					<p>Богд, Баруунбаян-Улаан, Нарийнтээл, Гучин-Ус, Уянга сумдын Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн, байгаль хамгаалагч нараар дамжуулан 8 сургууль, 1 цэцэрлэгийн 900 гаруй хүүхдүүдэд танин мэдэхүйн сургалт зохион байгууллаа. Түүнчлэн “Ан амьтад” гэрэл зургийн үзэсгэлэн, “Супер анги” шалгаруулах уралдаан, “Тарьц суулгацны үзэсгэлэн худалдаа”, “Тэрбум” мод тарих үндэсний хөдөлгөөний нээлт зэрэг арга хэмжээг зохион байгуулсан.</p> <p>-Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх-Орчны бохирдлыг бууруулах зорилтот жилийн ажлыг сурталчлах, иргэд олон нийтийг идэвхжүүлэх зорилгоор улс, орон нутгийн авто зам дагуу болон гэрэлтүүлгийн шонд нийт 240 ширхэг мэдээллийн самбар байршуулж, 2100 орчим гарын авлага, материалыг хэвлэж иргэд олон нийтэд хүргэсэн бөгөөд аймгийн хэмжээнд шилдэг тохижилт, ногоон байгууламжтай сум, байгууллага, аж ахуйн нэгж, айл өрх, сургууль цэцэрлэг шалгаруулах 20.0 сая төгрөгийн шагналын сантай болзолт уралдааныг зарлан, дүгнэж ажиллалаа.</p> <p style="text-align: center;">Хэрэгжилтийн хувь-100</p>
1.2.	Иргэн бүр байгаль хамгаалагч уриан дор байгаль орчныг хамгаалах, зөв дадал зуршил бий болгох зорилгоор нөлөөллийн арга хэмжээ хэрэгжүүлэх	-	<p>-Шинээр байгуулагдсан байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлийн тоо</p> <p>-Шинээр нэмэгдсэн идэвхтэн байгаль хамгаалагчийн тоо</p>	<p>Байгаль орчныг хамгаалж, үр шимийг хүртэх зорилгоор иргэд сайн дурын үндсэн дээр нэгдэн нөхөрлөж, үр дүн гаргасан байна.</p> <p>Идэвхтэн байгаль хамгаалагчийн тоо нэмэгдсэн байна.</p>	<p>Иргэн бүр байгаль хамгаалагч уриан дор байгаль орчныг хамгаалах, зөв дадал зуршил бий болгох зорилгоор байгальд ээлтэй аялах, хог хаягдлыг бууруулах, тарьсан мод бутыг арчлах, ургуулах чиглэлээр цуврал постерууд хийж цахим орчинд байршуулж иргэд олон нийтэд хүргэсэн. Аймгийн хэмжээнд байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр нийт 58 нөхөрлөл, мэргэжлийн байгууллага үйл ажиллагаа явуулдаг бөгөөд үүнээс 52 ой хамгаалах нөхөрлөл, 18 ойн мэргэжлийн байгууллага, 2 усны мэргэжлийн байгууллага, 5 ан амьтан хамгаалах иргэдийн нөхөрлөл, 10 идэвхтэн байгаль хамгаалагч ажиллаж байна. 2022 онд Уянга суманд 1 идэвхтэн байгаль хамгаалагч нэмж томилсон бөгөөд Төрийн хэмнэлтийн хуулийн дагуу урамшууллын асуудал шийдэгдээгүй.</p> <p>-“Тэрбум” мод үндэсний хөдөлгөөн, зорилтот жилийн нээлтийн арга хэмжээний үеэр зохион байгуулсан аймгийн зөвлөгөөнд байгаль хамгаалах нөхөрлөл, аж ахуйн нэгж,</p>

					идэвхтэн байгаль хамгаалагчдын төлөөллийг оролцуулж, уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулсан. Хэрэгжилтийн хувь 70
1.3.	Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлт гаргах процессыг и-монголиа цахим системд шилжүүлэх	-	Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлт гаргах процессыг и-монголиа цахим системд шилжүүлсэн эсэх	Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлт гаргах процессыг и-монголиа цахим системд шилжүүлсэн байна.	Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх, шат дамжлагыг бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх хүрээнд тус газраас иргэдэд үзүүлдэг ус ашиглуулах дүгнэлт, зөвшөөрөл, гүн өрмийн худаг гаргах зөвшөөрөл, усны мэргэжлийн байгууллагын эрх олгох дүгнэлт, аймгийн Засаг даргын тодорхойлолт зэрэг 5 төрлийн үйлчилгээг цахимжуулж, "E-MONGOLIA" СИСТЕМД-д шилжүүлж, 2022 оны 12 сарын 01-ний байдлаар 28 иргэн, аж ахуйн нэгжид байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлт гаргаж цахимаар хүргүүлсэн. Хэрэгжилтийн хувь-100
1.4.	Байгаль орчны эсрэг гэмт хэрэг зөрчлийг бууруулах зорилгоор МХГ, Цагдаагийн газартай хамтран байгаль орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын ажлыг зохион байгуулах	8.0 сая	-Хяналт шалгалтын тоогоор -Илрүүлсэн зөрчлийн тоо -Зарцуулсан төсөв	Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хууль хяналтын байгууллагуудтай хамтарсан хяналт шалгалтыг зохион байгуулж, шаардлагатай техник хэрэгслээр /GPS, зургийн аппарат/ хангасан байх	Байгаль орчны эсрэг гэмт хэрэг зөрчлийг бууруулах зорилгоор аймгийн МХГ, Цагдаагийн газар, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран ажиллах төлөвлөгөө гаргаж батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллалаа. 2022 онд хүрээлэн буй орчныг хамгаалах журмын эсрэг 103 зөрчлийн мэдээлэл бүртгэгдэж, 74 зөрчилд 42.1 сая төгрөгийн торгууль оногдуулж, байгальд учирсан хохирлын 53.3 сая төгрөгийг нөхөн төлүүлж, 4 зөрчлийн мэдээллийг хүлээн авахаас татгалзаж, 23 зөрчлийг харьяаллын дагуу бусад хуулийн байгууллагад шилжүүллээ. Нийт 1.5 төгрөгийн эд зүйлийг улсын орлогод оруулсан бөгөөд түлээний мод 4.12 м/куб, хэрэглээний мод 320 ширхэг, амьтны гаралтай мах түүхий эд 108 ширхэг, хөрөө 1, сүх 1, буу 2, машин 1, мал 2, тэрэг 1, байгалийн ургамал, ойн дагалт баялаг 201.12 кг хурааж шийдвэрлэсэн байна. Мөн хүрээлэн буй орчныг хамгаалах журмын эсрэг эрүүгийн 12 хэрэгт байгальд учирсан 95.9 сая төгрөгийг нөхөн төлүүлэхээр акт тогтоож, нийт байгальд учирсан 149.3 сая төгрөгийг нөхөн төлүүлэхээр актаар тогтоолоо. Аймгийн ГХУСАЗСЗ-өөс 2022 онд хүрээлэн буй орныг хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилсан сэргийлэх ажилд 9.3 сая төгрөг, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 8,0 сая төгрөг төсөвлөж, урьдчилан сэргийлэх ажлыг аймгийн

					хэмжээнд зохион байгуулан орон нутгийн түвшинд хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүний илрүүлэлт, шийдвэрлэлтийг сайжруулах, холбогдох байгууллагуудтай хамтын ажиллагааг бэхжүүлж ажилласны үр дүнд зөрчлийн тоо 2021 оноос 37 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Хэрэгжилтийн хувь-100
1.5.	ЗГ-ын 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 02 дугаар тогтоолоор батлагдсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын хэрэгжилтийг хангах	-	-Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого-50 хувь -Ойн нөөц ашигласны төлбөрийн орлого-85 хувь -Ус рашаан ашигласны төлбөрийн орлого-35 хувь	Ан амьтны нөөц ашигласны төлбөр-245,584,5 Ойн нөөц ашигласны төлбөр-400,000,0 Ус рашаан ашигласны төлбөр-364,152,2	Аймгийн ИТХ-ын “Аймгийн 2022 оны төсөв батлах тухай” 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 07/08 дугаар тогтоолоор байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал батлагдсан. Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газраас уг зардлаар нийт 14 арга хэмжээг хэрэгжүүлэхээр ЗГ-ын 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 02 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу төлөвлөгөө боловсруулж, аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, төлөвлөгөө, зардлын хуваарийг аймгийн Засаг даргын 2022 оны 01 сарын 31-ний өдрийн А/42 дугаар захирамжаар батлуулж хэрэгжилтийг ханган ажиллалаа. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого 2022 оны 11 сарын 29-ны байдлаар ан амьтны нөөц ашигласны төлбөр-2,4 тэрбум, ойн нөөц ашигласны төлбөр-680,0 сая, ус рашаан ашигласны төлбөр-321,9 мянган төгрөг тус тус төвлөрөөд байна. МУ-ын Засгийн газрын 2022 оны 02 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ыг танилцуулах, цувралт сургалтуудыг Байгаль орчин, аялал жуулчлалын яам, НҮБХХ-ийн “Биологийн олон янз байдлын санхүүжилтийн санаачилга-БИОФИН-2 төсөлтэй хамтран 4 удаа, АТГ-аас 2 удаа зохион байгуулж, аймаг, сумдын Засаг дарга, ИТХурлын дарга, төлөөлөгчид, БОХУБайцаагч, Байгаль хамгаалагч, Татварын байцаагч, Газрын даамлууд, Төрийн сангийн мэргэжилтнүүд хамрагдлаа. Хэрэгжилтийн хувь-100
1.6.	Байгаль орчны статистик тайланг /БОХ маягт/-ын		-Статистик мэдээний тоогоор	Байгаль орчны статистик үзүүлэлт	Байгаль орчны статистик мэдээ болох “БОХ” тайланг шинэчилсэн маягтын дагуу ойн сангийн өөрчлөлт, нөхөн

	мэдээллийг хуулийн хугацаанд холбогдох дээд байгууллагад тайлагнасан байх		-Хугацаандаа тайлагнасан эсэх	сайжирч, мэдээллийн хуулийн хугацаанд мэдээллийн системд оруулсан байна.	сэргээлт, ашигт малтмалын нөөцийн өөрчлөлт, ус ашиглалт, хамгаалалт, агнуурын нөөц ашиглалт хамгаалалт, хог хаягдлын чиглэлээр гарган тогтоосон хугацаанд 19 сумын 126 тайланг нэгтгэж, http://www.eic.mn/box/login.php хаягаар байгаль орчны мэдээллийн сангийн Вэб-д суурилсан программд шивэх, бүртгэх ажлыг 100 хувийн гүйцэтгэлтэй хийсэн. Хэрэгжилтийн хувь-100
1.7.	Шаардлагатай сумдад идэвхтэн байгаль хамгаалагч улирлын чанартай ажиллуулах, ажлын үр дүнгээр урамшуулах, иргэдийн мэдлэг, хандлагыг дээшлүүлэх, сургалт, зөвлөгөөн, туршлага судлах ажил зохион байгуулах	-	Идэвхтэн байгаль хамгаалагч ажиллуулах журмын хэрэгжилт хангагдсан байх	Шаардлагатай сумдад идэвхтэн байгаль хамгаалагч улирлын чанартай ажиллуулж, урамшуулсан байна.	2022 онд Уянга суманд 1 идэвхтэн байгаль хамгаалагч шинээр томилсон бөгөөд цалин урамшууллын асуудал Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу шийдвэрлэгдээгүй. Хэрэгжилтийн хувь 50.0
2. ОЙН БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗААЛТЫН ХҮРЭЭНД					
2.1.	"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг хангаж ажиллах;	-	-“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд зохион байгуулах арга хэмжээний стратеги төлөвлөгөө боловсруулагдсан эсэх -Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажилласан байдал	Аймгийн хэмжээнд 200,0 мянган ширхэг мод, бут	“Тэрбум” мод үндэсний хөдөлгөөний хүрээнд 2022-2030 оны хугацаанд тарих модны тооцоолол, стратеги, төлөвлөгөөний урьдчилсан төсөөллийг боловсруулж БОАЖЯам, Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлсэн. Улсын хэмжээний стратеги төлөвлөгөө батлагдсаны дараа аймгийн нарийвчилсан төлөвлөгөөг 2023 онд хийгдэх аймгийн Ойн менежментийн төлөвлөгөөтэй хамтатган шинэчлэн боловсруулж батлуулахаар төлөвлөж байна. Аймгийн хэмжээнд “Тэрбум” мод үндэсний хөдөлгөөн, бүх нийтээр мод тарих хавар, намрын өдрүүдийн хүрээнд нийт 320.0 мянган ширхэг мод, бут тарьж, нийт тарьсан модны 36.0 мянган ширхэгийг айл өрх, 70.0 мянган орчим ширхэгийг албан байгууллага, аж ахуйн нэгжүүд, 140.0 мянган ширхэгийг төв суурин газрын нийтийн эзэмшлийн ногоон байгууламжид, 74.0 мянган ширхэгийг ойжуулалт, хамгаалалтын ойн зурваст тарьж мод бут тарих ажилд нийт 492 аж ахуйн нэгж, байгууллага, 16428 иргэн оролцож, тарьсан модны амьдралтын хувь дундажаар 80 хувьтай ургасан байна.

					Хэрэгжилтийн хувь 100
2.2.	Мод, сөөгийн үрийн нөөц бүрдүүлэх ажлыг зохион байгуулах;	-	Аймагт шаардлагатай мод, сөөгийн үрийн нөөц бүрдүүлсэн байх	-Шилмүүст модны үр-200кг -Навчит модны үр-400кг	Өвөрхангай аймгийн мод үржүүлгийн үйл ажиллагаа явуулдаг ойн мэргэжлийн байгууллага, аж ахуйн нэгж иргэд шинэсний үр-180 кг, хайлаас, шар хуайсны үр 300 кг, загийн үр 3 кг, бусад мод сөөгний үр 40 кг түүж бэлтгэсэн байна. Хэрэгжилтийн хувь-100
2.3.	Жилд 1.0-1.5 сая ширхэг тарьц ургуулах мод үржүүлгийн газар 3-аас доошгүйг шинээр байгуулах ажлыг эхлүүлэх;	216.0 сая	-Өргөтгөж шинээр байгуулагдсан газрын тоо -Тарьц суулгацын тоог нэмэгдүүлсэн байдал	2022 онд 3-аас доошгүй мод үржүүлгийн газар байгуулах	Зорилтот жилийн хүрээнд орон нутагт мод үржүүлгийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн чадавхыг бэхжүүлэх зорилгоор хангай, тал хээр, говиор бүсчилэн “Арвайхээр цэцэрлэгжилт” ОНӨААТҮГ, “Сум дундын Ойн анги”, “Өгөөмөр шунхлай” ХХК, “Бат-цэцэрлэгжилт” ХХК, “Өв-эхлэл өнгө” ХХК, “Их говийн төгөл” ХХК зэрэг 6 аж ахуйн нэгж, байгууллагад 216,0 сая төгрөгийн дэмжлэгийг орон нутгийн төсвөөс олголоо. Тус аймагт 2021 онд байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн мод үржүүлгийн 10 газарт 15 нэр төрлийн нийт 327.9 мянган тарьц, суулгац ургуулж байсан бол, 2022 онд мод үржүүлгийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх 11 аж ахуйн нэгж, иргэн нэмэгдэж, мод үржүүлгийн 21 газарт 18 нэр төрлийн 2.0 сая орчим тарьц суулгац ургуулаад байна. Хэрэгжилтийн хувь-100
2.4.	Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд ойн зурвас, ойн төгөл байгуулах зорилгоор 300 га талбайг тусгаж, шийдвэрлэх;	-	-Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгасан эсэх	300 га талбай	Газар зохион байгуулалтын 2022 оны төлөвлөгөөнд 13 суманд 458,7 га газрыг мод тарих, ногоон байгууламж байгуулах, мод үржүүлгийн газар байгуулах иргэн аж ахуйн нэгжид олгохоор тусгаж 100 орчим га талбайг мод үржүүлэг, ойн зурвас, ногоон байгууламж байгуулах зориулалтаар олгосон байна. Хэрэгжилтийн хувь-100
2.5.	Мод, сөөгийн тарьц, суулгацын нөөц бүрдүүлэх ажлыг зохион байгуулах;	-	Мод, сөөгийн тарьц, суулгацын нөөц бүрдүүлсэн байдлаар	-Шилмүүст модны тарьц, суулгац 0.150 сая.ш (150.0 мянга) -Навчит модны тарьц, суулгац-0.3 сая.ш (300,0 мянга)	Өвөрхангай аймгийн хэмжээнд 2021 онд байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн 10 мод үржүүлгийн газарт 15 нэр төрлийн нийт 327.9 мянган тарьц суулгац ургуулж байсан бол 2022 онд мод үржүүлгийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, иргэдийн тоо 11-ээр нэмэгдэж 21 мод үржүүлгийн газарт 18 нэр төрлийн 2 сая орчим тарьц суулгац ургуулсан байна. Нийт ургуулсан тарьц суулгацын дотор 2 настайгаас дээш буюу 2023 онд ойжуулалт цэцэрлэгжүүлэлтэд шилжүүлэх тарьц суулгац 340.0 мянга орчим байгаа бол 2024 оноос эхлэн жил тутам 1200.0

					мянгаас дээш тооны тарьц суулгацыг нийлүүлэх боломжтой болсон. Хэрэгжилтийн хувь-100
2.6.	0.6 сая-с доошгүй мод тарьсан байна	-	Тэрбум мод хөдөлгөөний хүрээнд тарих модны тоо	0,6 саяас доошгүй мод тарих	Аймгийн хэмжээнд “Тэрбум” мод үндэсний хөдөлгөөн, бүх нийтээр мод тарих хавар, намрын өдрүүдийн хүрээнд нийт 320.0 мянган ширхэг мод, бут тарьж нийт тарьсан модны 36.0 мянган ширхэгийг айл өрх, 70.0 мянга орчим ширхэгийг албан байгууллага, аж ахуйн нэгжүүд, 140.0 мянган ширхэгийг төв суурин газрын нийтийн эзэмшлийн ногоон байгууламжид, 74.0 мянган ширхэгийг ойжуулалт, хамгаалалтын ойн зурваст тарьж мод бут тарих ажилд нийт 492 аж ахуйн нэгж, байгууллага, 16428 иргэн оролцож, тарьсан модны амьдралтын хувь дундажаар 80 хувьтай ургасан байна. Хэрэгжилтийн хувь-70
2.7.	Ойжуулалт, ойн зурвас байгуулах ажил гүйцэтгэх	Улс, орон нутаг	Ойн зурвас шинээр байгуулсан газар (га-гаар)	25 га	2022 онд Бат-Өлзий сумын ойгоос мод бэлтгэсэн аж ахуйн нэгж, нөхөрлөлүүд Ойн ангиас шийдвэрлэсний дагуу өөрийн хөрөнгөөр гүйцэтгэх ойжуулалтын ажлыг дүйцүүлж, сумын төвийн нийтийн эзэмшлийн талбайд 9000 ширхэг модыг тарьсан бөгөөд шинэсний тарьцаар гүйцэтгэх ойжуулалтын ажил 10 га талбайд хийгдсэн. Хархорин суманд газар тариалан эрхэлдэг 16 аж ахуйн нэгж 10 га талбайд хамгаалалтын ойн зурвас байгуулж, 16.0 мянга, Төгрөг сумын Мазарт 6 га талбайг хашиж агро ойжуулалтаар 1200 ширхэг мод тус тус тарьсан. Улсын чанартай авто зам дагуу мод тарих ажлыг эхлүүлж Арвайхээр суманд 2500 м, Хужирт суманд 800 м, Хархорин суманд 900 м, нийт 4.2 км урт ойн зурвас байгууллаа. “ӨВ-АЗЗА” ТӨХКомпани Бүрд сумын Шариланд 1 га талбайд “Алтан шар зам” төгөл байгуулж 1000 ширхэг мод тарьсан. Улсын төсвийн 90,0 сая төгрөгийн санхүүжилтээр газрын доройтол, цөлжилтөөс сэргийлэх хөтөлбөрийн хүрээнд Баруунбаян-Улаан суманд 8 га хамгаалалтын ойн зурвас байгуулах ажлыг “Их сумт хайрхан” ХХКомпани гүйцэтгэлээ. Хэрэгжилтийн хувь-100

2.8.	Ойн хөнөөлт шавьжтай тэмцэх устгал тэмцлийн ажил гүйцэтгэх	86.0 сая	-Хөнөөлт шавьжтай тэмцэх ажил хийгдсэн га	2000 га-д	Тус аймагт ойн хөнөөлт шавжийн хөнөөлийн голомт ой бүхий 5 сумын 30.0 мянга орчим га талбайг хамарсан. Шинэсний шилмүүс хуйлагч, яacobсоны төөлүүрч эрвээхэйн хөнөөлийн голомт илэрсэн Бат-Өлзий, Зүүнбаян-Улаан, Хужирт, Хархорин сумдын ойн сан бүхий газруудаар ойн хөнөөлт шавжтай үүргийн шүршигч багаж ашиглан тэмцэх ажлыг 2022 оны 06 сарын 18-28-ныг хүртэлх хугацаанд хийлээ. Уг ажлын гүйцэтгэгчээр “Гранд Форест” ХХКомпани шалгарч Бат-Өлзий суманд 1000 га, Хужирт суманд 500 га, Зүүнбаян-Улаан суманд 500 га, Хархорин суманд 500 га талбайд гүйцэтгэж уг арга хэмжээнд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 86,0 сая төгрөгийн санхүүжилт олголоо. Мөн Бат-Өлзий, Хужирт сум, сум дундын Ойн ангиас нэмэлт хөрөнгө гаргаж 1300 га талбайд устгалын ажил хийснээр аймгийн хэмжээгээр нийт 3800 га талбайд ойн хөнөөлт шавжтай тэмцэх ажил хийгдсэн. Хэрэгжилтийн хувь-100
2.9.	Мод тарих газрын хамгаалалтын хайс, хашаа барих	75.6 сая	-Шинээр нэмэгдүүлсэн хамаалалтын хайс, хашааны уртаар -Зарцуулсан хөрөнгийн хэмжээгээр	Хашааны материал нийлүүлэгдсэн байна.	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар гүйцэтгэх мод тарих газрын хамгаалалтын хашаа барих ажлын гүйцэтгэгчээр “Их өшгөг” ХХК шалгарч, Арвайхээр сумын нийтийн эзэмшлийн талбай, Цэргийн анги, УБ-Арвайхээрийн авто замын дагуу мод тарих 4 хэсэг талбайд 6300 м урт хамгаалалтын хашаа барьсан. Уг ажилд байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 75.6 сая төгрөгийн хөрөнгө зарцуулж хашааны шонд “Арвайхээр тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ газрын хаягдал хуванцараар хийсэн шонг ашигласан. Аймгийн хэмжээгээр мод тарьсан газрыг услах зориулалтаар нийт 19 худаг, 2200 метр усалгааны систем, 27000 уртааш метр хайс хашаа хийгдсэн. Хэрэгжилтийн хувь-100
2.10.	“Тэрбум” мод хөдөлгөөний хүрээнд төв суурин газрын нийтийн эзэмшлийн талбайд тарих модны тарьц, суулгац худалдан авч сумдад нийлүүлэх	60.0	-Нийлүүлсэн тарьц суулгацын тоогоор -Нийлүүлсэн сумдын тоогоор	10000 ш	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 2022 онд Өвөрхангай аймгийн төв суурин газрын нийтийн эзэмшлийн талбайд тарих модны тарьц суулгац, нийлүүлэх ажлын гүйцэтгэгчээр “Арвайхээр-Цэцэрлэгжилт” ОНӨААТҮГ газар шалгарч нийт 3 нэр төрлийн 17110 ширхэг модны тарьц суулгац худалдан авч 17 суманд нийлүүлээ. Уг ажилд 60,0

					<p>сая төгрөгийн санхүүжилт олголоо. Мөн аймгийн зорилтот жилийн үйл ажиллагааны зардлаар 13000 ш, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас дэмжлэг авч мод үржүүлгийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн чадавхыг бэхжүүлэх, тарьц суулгац нийлүүлэх ажил гүйцэтгэсэн 6 аж ахуйн нэгж 21650 ш, сумдууд зорилтот жилийн хүрээнд орон нутгийн хөгжлийн сан, орон нутгийн төсвөөс 50 гаруй мянган ширхэг, хувийн хэвшил, иргэдийн хандив тусламжаар 30 мянга орчим тарьц суулгац нийлүүлж төв суурин газрын нийтийн эзэмшлийн ногоон байгууламжид тарьжээ.</p> <p>Хэрэгжилтийн хувь-100</p>
2.11.	Сум дундын Ойн ангийн мод үржүүлгийн газрын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж тарьц, суулгацын нөөцийг нэмэгдүүлэх	<p>БОХН САХ-16.0 сая, Зорилтот жилийн зардлаас-30,0 сая</p>	<p>-Тарьц, суулгацын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн үйл ажиллагаа</p> <p>-Зарцуулсан хөрөнгийн хэмжээгээр</p>	150,000-аас доошгүй	<p>2022 онд Сум дундын Ойн ангийн мод үржүүлгийн газрыг 3 га талбайгаар өргөтгөж хөрс боловсруулах, тарьц суулгац ургуулах ажил төлөвлөгөөний дагуу бүрэн хийгдлээ. Мод үржүүлгийн газарт шаардлагатай үр, мөчир бэлтгэх, бордоо, ариутгалын бодис, хүлэмж, усалтын систем авах, гэрээт ажилтан ажиллуулах зэрэг ажилд дэмжлэг үзүүлж БОХНСАХэмжээний зардлаас 16,0 сая төгрөг, аймгийн зорилтот жилийн үйл ажиллагааны зардлаас 30.0 сая төгрөгийн санхүүжилт тус тус олголоо. 2022 онд Ойн ангийн мод үржүүлгийн газарт, шинэсний тарьц 160 мянга, навчит модны тарьц, суулгац 287 мянган ширхэг, нийт 447 мянган ширхэг тарьц суулгац ургуулсан байна.</p> <p>Хэрэгжилтийн хувь-100</p>
3. УСНЫ НӨӨЦИЙН АШИГЛАЛТ, ХАМГААЛАЛТЫН ТАЛААР ТУСГАГДСАН ЗААЛТЫН ХЭРЭГЖИЛТ					
3.1.	Булаг шанд, рашааны эхийг хамгаалах	14.0	-Эхийг хамгаалсан булаг шанд, рашааны тоо	Шаардлагатай газруудад 20-иос доошгүй булаг шанд, рашааны эхийг хашиж хамгаалсан байна.	<p>2022 онд улс, орон нутаг, хувийн хэвшлийн хөрөнгөөр Баруунбаян-Улаан, Баянгол, Нарийнтээл, Өлзийт, Баян-Өндөр, Хужирт, Хархорин, Бат-Өлзий сумдад нийт 33 булаг шанд, рашааны эхийг хашиж хамгаалан, нутгийн иргэдтэй хариуцан хамгаалах гэрээ байгуулан хүлээлгэн өгсөн.</p> <p>Хэрэгжилтийн хувь-100</p>
3.2.	Рашааны тоо бүртгэлийг зохион байгуулж, орон нутгийн чанартай, бүрэн судлагдаагүй рашааны чанар найрлагыг	15.0	Рашааны физик-химийн найрлагыг мэргэжлийн байгууллагаар тогтоолгосон рашааны тоогоор	Мэргэжлийн байгууллагаар 3-с доошгүй рашааны физик-химийн найрлагыг тодорхойлсон байна.	Орон нутгийн чанартай, бүрэн судлагдаагүй Бат-Өлзий сумын Хуст, Ар хятруун, Могойт, Үүртийн тохой, Баруунбаян-Улаан сумын Хүрэн хад, Уянга сумын Өвөр хятруун, Тарагт сумын Хүрэмт, Эмт, Арвайхээр сумын Дэлгэрэх, Бурхи зэрэг рашаануудын физик, химийн найрлагыг тодорхойлох судалгааны ажлыг 2022 оны 06-09

	тодорхойлох судалгаа хийлгэнэ.				сарын хугацаанд МУ-ын усны чанарын зөвлөх инженер, гидрохимич Ч.Жавзан доктороор ахлуулсан судалгааны багаар гүйцэтгүүлсэн. Хээрийн судалгааны ажлаар холбогдох аргачлалын дагуу усны сорьц авч, ерөнхий химийн болон бохирдлын шинжилгээг Газарзүй-Геоэкологийн хүрээлэнгийн Усны шинжилгээний лабораторид, бичил амь судлалын шинжилгээг газар дээр нь болон сорьц авч биологийн хүрээлэнгийн микробын нийлэгжлийн лабораторид, бичил элементийн дэлгэрэнгүй шинжилгээг “SGS IMME Mongolia” ХХК-ний лабораторид ICP80T маркийн багажаар тус тус тодорхойлуулж, судалгааны тайланг аймгийн ИТХ-аар хэлэлцүүлж, хүлээн авсан. Хэрэгжилтийн хувь-100
3.3.	Аймгийн төвийн ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн хориглолт хязгаарлалтын бүсийг шинэчлэн тогтоож, хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх	-	Хуучин тогтоосон бүсийг шинэчилсэн эсэх	Шинээр тогтоосон бүсийг хамгаалах, тэмдэгжүүлэх	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны А/36 дугаар тогтоолоор Арвайхээр сумын ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн хориглолт ба хязгаарлалтын бүсийг 9.5 га газарт тогтоон, дэглэмийг мөрдүүлж, Арвайхээр сумын төвлөрсөн ус хангамжийн эрүүл ахуйн хязгаарлалтын бүсэд орсон айлыг нүүлгэн шилжүүлж, “Цуврайн гол” ХХК-иар ариутгал халдваргүйжүүлэлтийг хийлгэсэн. Хэрэгжилтийн хувь 100
3.4.	“Тэрбум” мод тарих хүрээнд мод тарих бүсийн ус хангамжийг шийдвэрлэх төлөвлөгөө боловсруулж хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх	-	Мод тарих газрын усалгааны эх үүсвэрийг шийдвэрлэсэн эсэх	-Мод тарьсан газруудын усалгааны асуудлыг шийдвэрлэж ажилласан байна.	“Тэрбум” мод үндэсний хөдөлгөөн, зорилтот жилийн хүрээнд мод тарих бүсийн ус хангамжийг шийдвэрлэх хүрээнд “Хөдөө аж ахуйг дэмжих сан”-гийн хөнгөлөлтөд 2 аж ахуйн нэгж хамрагдаж, хямд өртөгтэй дуслын болон намираа усалгааны систем, усны нөөцийн сав, бусад тоног төхөөрөмж, Арвайхээр сумын “Их монгол” цэцэрлэгт хүрээлэнд 10 га-гийн дуслын усалгааны систем зэргийг тухайн сангаас хөнгөлөлттэй нөхцлөөр худалдан авсан. Аймгийн хэмжээгээр мод тарьсан газрын усалгаанд зориулж гүн өрмийн 16 худаг, гар худаг 3-г шинээр гаргаж, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл авахад нийт 514.1 сая төгрөг, ногоон байгууламжийн хашаа барих, мод тарихад 947.6 сая төгрөгийг төр, хувийн хэвшлээс зарцуулсан байна. Хэрэгжилтийн хувь 100

3.5.	Уянга, Зүүнбаян-Улаан, Тарагт сумын усны сан бүхий газарт хамгаалалтын бүс тогтоож, тэмдэгжүүлэх	2.0 сая	Уянга, Зүүнбаян-Улаан, Тарагт сумын усны сан бүхий газарт хамгаалалтын бүсийг хуулийн хүрээнд тогтоосон эсэх	Уянга, Зүүнбаян-Улаан, Тарагт сум	Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын бүсийг тогтоож, тэмдэгжүүлэх ажлын удирдамжийн хүрээнд Уянга, Зүүнбаян-Улаан сумдад 10 дугаар сарын 26-30-ны өдрүүдэд ажилласан. Удирдамжийн дагуу дээрх сумдын уст цэгүүдийн мэдээллийг багийн Засаг дарга болон нутгийн малчидтай хамтран газар болон нэрийн зурагтай тулгаж, нэршлийн зөрүүтэй уст цэгүүдийн мэдээллийг шинэчилж, ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөлтэй талбайд хэмжилт хийж, тэмдэгжүүлэлтийн ажлыг хийж гүйцэтгэлээ. Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын бүсийг тогтоох ажлын суурин боловсруулалтыг ArcGis программ ашиглан хийсэн. Хэрэгжилтийн хувь 100
3.6.	Шаардлагатай газарт хөв цөөрөм байгуулах зураг төсөв хийлгэх	19.5 сая	Зураг төсөв хийгдсэн эсэх	Хөв цөөрөм байгуулах зураг төсөв хийгдсэн байна.	Нарийнтээл сумын "Их булаг" хэмээх газарт хөв цөөрөм байгуулах зураг төсөл боловсруулах ажлыг усны мэргэжлийн байгууллага болох "Гидрофонтан" ХХКомпаниар гүйцэтгүүлж, улсын экспертизээр баталгаажсан тайлан, зураг төсвийг хүлээн авсан. Хэрэгжилтийн хувь 100
4.ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН, БАЙГАЛИЙН НӨӨЦИЙГ ХАМГААЛАХ ТАЛААР ТУСГАГДСАН ЗААЛТЫН ХЭРЭГЖИЛТ					
4.1.	Зэрлэг амьтдад зориулж биотехникийн арга хэмжээ авах	10.0	Зэрлэг амьтны амьдрах орчныг сайжруулах чиглэлээр хийгдсэн үйл ажиллагааны тоогоор	Зэрлэг амьтны амьдрах орчныг сайжруулж хоол тэжээл, усан хангамжийг нэмэгдүүлэх арга хэмжээ хэрэгжүүлсэн байна.	Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар тус газраас 2022 оны 3,4 дүгээр саруудад нэн ховор, ховор амьтдад болох аргаль, янгир, халиун буга, бор гөрөөс зэрэг амьтдад биотехникийн арга хэмжээ авах ажлыг агнуурын бүс нутагт зохион байгууллаа. Нийт 10 сумын 36 цэгт 5 тонн хужир тавьж, тус ажилд сумдын БОХУБайцаагч, байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтнүүд, байгаль хамгаалагчид, нөхөрлөлийн гишүүд хамтран зохион байгууллаа. Хэрэгжилтийн хувь-100
4.2.	Мал, амьтны гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор цагаан зээрээс шинжилгээ авах ажлыг зохион байгуулах		Шинжилгээний үр дүнгээс хамааран авч хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсан байна.	Тус аймгийн Баян-Өндөр сумын нутагт малын гоц халдварт шүлхий өвчин гарч сумын хэмжээнд хорио цээрийн бүс тогтоон ажилласан. Хорио цээр тогтоосон газруудад цагаан зээр олноор байршиж, тухайн цагаан зээрийн сүрэгт сэжигтэй шинж тэмдэгүүд илэрч байсан тул шинжилгээний зориулалтаар нэг цагаан зээр агнах зөвшөөрлийг

					БОАЖЯамнаас авч холбогдох суманд хүргүүлж, шинжилгээ хийлгэх ажлыг зохион байгуулсан. Хэрэгжилтийн хувь-100
4.3.	Хөрсний доройтлоос урьдчилан сэргийлэх зорилгоор хөрсөнд үл нэвчих “Эко” ариун цэврийн байгууламж байршуулах	38.0	Шинээр байгуулсан Эко ариун цэврийн байгууламжийн тоогоор	Хөрсний доройтлоос урьдчилан сэргийлсэн байх	Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх-Орчны бохирдлыг бууруулах зорилготой жилийн хүрээнд аймгийн хэмжээнд гэр хорооллын айл өрх болон албан байгууллагууд өөрсдийн санаачилгаар нүхэн жорлонгоо сайжруулж, хөрсөнд үл нэвчих 1043 ширхэг ариун цэврийн байгууламжийг шинээр байгуулж, хөдөөгийн малчин айл өрхүүд өвөлжөө, хаваржаа, зуслан, намаржааны газрууддаа жорлонтой болох ажлыг бүх сумдад зохион байгуулж, үүний үр дүнд 2365 айл нүхэн жорлонтой болсон. Байгаль орчин, аялал жуулчлалын газраас 2022 онд аялал жуулчлалын эвент арга хэмжээнд зориулж байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний 38.0 сая төгрөгийн хөрөнгөөр 17 суултуур бүхий 3 ш зөөврийн эко ариун цэврийн байгууламж худалдан авч эвент арга хэмжээнүүдэд ашиглаж байна. Хэрэгжилтийн хувь-100
4.4.	Хог хаягдлын менежментийг сайжруулах стратеги төлөвлөгөөг боловсруулж, батлуулах	-	Хог хаягдлын менежментийг сайжруулах мастер төлөвлөгөөг боловсруулж, баталгаажуулсан эсэх	Стратеги төлөвлөгөө боловсруулагдан, хэрэгжилт үр дүнг тооцож ажилласан байна.	Азийн хөгжлийн банкны ядуурлыг бууруулах Япон сангийн буцалтгүй тусламжаар хэрэгжиж буй Арвайхээр хотын хатуу хог хаягдлын менежментийг сайжруулах төслийн хүрээнд “Хог хаягдлын менежментийг сайжруулах стратеги төлөвлөгөө”-г аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 09/09 дүгээр тогтоолоор батлуулж сумдад хүргүүлсэн. Хэрэгжилтийн хувь-100
4.5.	Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах үйл ажиллагааг дэмжих, сумдыг дахивар бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэх боломжоор хангах	-	Хог хаягдлыг ангилан ялгах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлсэн байдал:	Шаардлагатай сумдад хоёрдогч түүхий эд нягтруулж, пресслэх төхөөрөмж нийлүүлсэн байна.	Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах дадал хэвшлийг айл өрхүүдэд хэвшүүлж, дахивар бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэх ажлын хүрээнд 13 суманд хоёрдогч түүхий эд хүлээн авах 28 цэг байгуулагдаж, 301,8 тн дахивар хаягдлыг цуглуулан аймгийн төвд үйл ажиллагаа явуулдаг “Эко цэнэ”, “Цэмцгэр” төвүүд болон Улаанбаатар хот руу нийлүүлээд байна. Есөнзүйл, Гучин-Ус, Баян-Өндөр, Уянга, Бүрд, Арвайхээр сумд 2022 онд орон нутгийн хөгжлийн сангийн 69,0 сая төгрөгийн хөрөнгөөр хоёрдогч түүхий эдийг нягтруулах пресслэгч төхөөрөмжийг худалдан авч, аймгийн хэмжээнд 12 сум, 19 пресслэх төхөөрөмжтэй болоод байна.

					<p>“Арвайхээр тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ газар 2021 оны 10 дугаар сараас эхлэн “Хаягдал хуванцар дахин боловсруулах” үйлдвэр байгуулан үйл ажиллагаа явуулж эхэлсэн. БОАЖГ-аас үйлдвэрийг дэмжин байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд нийтийн эзэмшлийн талбайд тарих мод, бутны хамгаалалтын ажилд шаардагдах хоёрдогч түүхий эд боловсруулж хийсэн хашааны шон нийлүүлэх ажилд 18,0 сая төгрөгийн санхүүжилт олгосон.</p> <p>“Азийн хөгжлийн банкны ядуурлыг бууруулах Япон сангийн хөрөнгөөр хэрэгжиж буй Арвайхээр хотын хатуу хог хаягдлын менежментийг сайжруулах төслийн хүрээнд Арвайхээр суманд пүү болон хоёрдогч түүхий эд хүлээн авах 5 цэгийг шинээр байгуулж, “Арвайхээр тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-т хүлээлгэн өгсөн.</p> <p>Хэрэгжилтийн хувь-100</p>
4.6.	Аюултай хог хаягдлыг түр хадгалах агуулахын менежментийг хариуцах байгууллагыг сонгон шалгаруулах	-	Сонгон шалгаруулсан эсэх	Аюултай хог хаягдлын тооллого зохион байгуулсан байна.	Аюултай хог хаягдал хадгалах агуулахын барилгыг хүлээн авсны дараа хариуцах байгууллагыг сонгон шалгаруулна.
4.7.	Нутаг дэвсгэрийн хэмжээнд Аюултай хог хаягдлын тооллогыг зохион байгуулах	ОНТ 19.8 сая	Аюултай хог хаягдлын тооллого зохион байгуулах эсэх	Аюултай хог хаягдлын тооллого зохион байгуулсан байна.	<p>"Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх-Орчны бохирдлыг бууруулах" зорилтот жилийн хүрээнд химийн хортой болон аюултай бодисын тооллогын ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулж, Ерөнхий боловсролын 24 сургуулийн химийн кабинет, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Мал эмнэлгийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв болон Хужирт сумын "Жем Хужирт" ХХК-ийн лабораториудад хадгалагдаж байсан ашигладаггүй, хугацаа дууссан шингэн 407,5 л, хатуу болон нунтаг 462,3 кг бодис, 30 тн химийн бордоо зэрэг давхардсан тоогоор 1584 нэр төрлийн химийн аюултай бодисуудыг мэргэжлийн байгууллага болох "Түмэн эгшиг" ХХК-тай гэрээ байгуулан Улаанбаатар хот руу тээвэрлүүлж, устгуулах ажлыг 19 сумын ЗДТГ, холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгууллаа. Уг арга хэмжээнд орон нутгийн төсвөөс 19,8 сая төгрөг зарцуулсан.</p> <p>Хэрэгжилтийн хувь-100</p>

4.8.	Аюултай хог хаягдлыг түр хадгалах агуулахыг барьж дуусгаж, хэвийн үйл ажиллагааг хангах нөхцөлийг бүрүүлэх	-	Агуулахын барилгыг хүлээн авсан байна.	Аюултай хог хаягдлын түр хадгалах агуулахын хэвийн үйл ажиллагаа хангагдсан байна.	БОАЖЯам, Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооноос зарлагдсан “Өвөрхангай, Булган, Архангай аймгуудад аюултай хог хаягдлыг хадгалах, агуулахын жишиг зураг, төсөв боловсруулж батлуулах, стандартын шаардлага хангасан аюултай хог хаягдлын агуулахыг барих” нээлттэй тендерийн гүйцэтгэгчээр “ЖАМ” ХХК шалгарч Байгаль орчин, аялал жуулчлалын яамтай гэрээ байгуулан агуулахын барилгын ажлыг гүйцэтгэж байна. Аймаг, орон нутгийн мэргэжлийн байгууллагуудын зүгээс ажлын явцад 3 удаагийн хяналт тавьж ажлын гүйцэтгэл 70 хувьтай явагдаж байна. Хэрэгжилтийн хувь-70
4.9.	Орон нутагт газар ашиглагч иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад байгаль орчинд ээлтэй хэрэглээний соёл хэвшүүлэх, хог хаягдлыг ангилан ялгах дадал зуршлыг төлөвшүүлэх, хүний эрүүл мэнд байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар сургалт, семинарыг үе шаттайгаар зохион байгуулах	-	-Сургалт, семинарын тоогоор -Сургалт, семинарт хамрагдсан иргэдийн тоогоор	Аймгийн төв, сумдын хэмжээнд сургалт, семинарыг үе шаттайгаар зохион байгуулсан байна. Сургалтад 250-аас доошгүй иргэдийг хамруулсан байна.	-Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх-Орчны бохирдлыг бууруулах зорилтот жилийн хүрээнд Монголын хог хаягдлыг дахин боловсруулах үндэсний холбоотой хамтран хог хаягдлын салбарын өнөөгийн нөхцөл байдал, хог хаягдлыг дахин боловсруулах арга хэмжээний талаар сумдын Засаг дарга, байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтнүүд, байгаль хамгаалагч нар болон хог хаягдлын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэн аж ахуйн нэгжийн төлөөлөл 250 гаруй хүн хамрагдсан. -Хог хаягдлыг ангилан ялгах дадал хэвшлийг төлөвшүүлэх, хүний эрүүл мэнд байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр иргэд, өсвөр үеийнхэнд зориулсан сургалтыг 11 удаа зохион байгуулж, 600 гаруй иргэн, Азийн хөгжлийн банкны ядуурлыг бууруулах Япон сангийн буцалтгүй тусламжаар хэрэгжиж буй Арвайхээр хотын хатуу хог хаягдлын менежментийг сайжруулах төслийн хүрээнд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх ур чадварыг сайжруулах, хөгжүүлэх 3 удаагийн сургалтыг зохион байгуулж сургалтад 160 гаруй иргэнийг хамруулсан. -Хүрээлэн буй орчин, нийтийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлийг судлах, байгальд ээлтэй, эерэг хандлагатай соёлч боловсон, зөв дадалтай иргэн, хамт олон байх, хотын соёлыг төлөвшүүлэхэд тулгамдаж буй асуудлыг тодорхойлох зорилгоор “ЭРҮҮЛ ОРЧИН-ХОТЫН СОЁЛ” сэдэвт онол практикийн бага хурлыг 2 үе шаттай зохион байгуулсан.

					Өвөрхангай аймгийн баяр наадмын үеэр Лаборатори Мэргэд сургуулийн эко клубын сурагчидтай хамтран наадмын талбайд хог хаягдлын чиглэлээр нөлөөллийн ажлыг зохион байгуулсан. Тус арга хэмжээнд иргэдэд цэвэрхэн наадацгаая 4 төрлийн постер, 1 видео шторк бэлтгэж наадмын талбай болон талбайн гадна худалдаа үйлчилгээ эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудыг ил задгай хог хаяхгүй байх цэвэрхэн наадахыг уриалж цахим хуудсуудаар дамжуулан сурталчилж ажилласан. Хэрэгжилтийн хувь 100
4.10.	Агаарын чанарыг сайжруулах бүс, бүсэд мөрдөх журам батлах	-	-Журам батлагдсан эсэх	Агаарын чанарыг сайжруулах бүсэд мөрдөх журмыг улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн байна.	-Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд, Өвөрхангай аймгийн Засаг даргын хамтарсан 2016 оны А/73, а/149 дугаар тушаалаар Арвайхээр сумын агаарын чанарыг сайжруулах бүсийг тогтоож, бүсэд мөрдөх журмыг баталсан бөгөөд Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Өвөрхангай аймгийн Засаг даргын хамтарсан 2022 оны 10 дугаар сарын 19-ны өдрийн А/425, А/489 тушаал, захирамжаар Агаарын чанарыг сайжруулах бүс тогтоох, бүсэд мөрдөх журмыг шинэчлэн батласан. Хэрэгжилтийн хувь 100
5. ТУСГАЙ ХАМГААЛАЛТАЙ ГАЗАР НУТГИЙГ ХАМГААЛАХ ТАЛААРХ ЗААЛТЫН ХЭРЭГЖИЛТ					
5.1.	Аймгийн томоохон голуудын урсац бүрэлдэх эхийг улсын тусгай хамгаалалтад авах	-	Аймгийн томоохон голуудын урсац бүрэлдэх эхийг улсын тусгай хамгаалалтад авах үндэслэлийг боловсруулан аймаг, сумын ИТХ-ын саналыг БОАЖЯаманд хүргүүлсэн байх	Шаардлагатай газруудыг тусгай хамгаалалтад авсан байна.	Онги, Таац голын урсац бүрэлдэх эх бүхий Уянга, Бат-Өлзий, Зүүнбаян-Улаан, Хужирт, Нарийнтээл сумдын нутагт орших “Хангайн нуруу”-ны салбар уулсын үзүүр төгсгөл хэсэг, гол мөрний урсац бүрэлдэх эх бүхий Баруунбаян-Улаан, Богд сумдын нутагт орших “Зүүн богд уул”-ыг байгалийн нөөц газрын ангиллаар Улсын тусгай хамгаалалтад авахуулах саналыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн, саналыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар 2022 оны 02 сарын 24-ны өдөр хэлэлцүүлсэн. Зүүнбаян-Улаан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар тус суманд хамаарах газар нутгийг Улсын тусгай хамгаалалтад авах асуудал дэмжигдээгүй тул дахин сумын хурлаар хэлэлцүүлэхээр холбогдох саналыг хүргүүлсэн. Тухайн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн асуудлыг одоогоор хэлэлцээгүй байна

					Хэрэгжилтийн хувь-70
5.2.	Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд туссан улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөтгөх газруудыг үе шаттайгаар хамгаалалтад авах ажлыг зохион байгуулж, ЗГ-ын 2018 оны 384 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах	-	Төлөвлөгөөнд тусгаж хил зааг, байршил хэмжээг мэдээллийн санд бүртгэж ИТХ-аар батлуулсан байна.	Улсын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан байршлууд: Арц богд, Бага богд, Бага богдын нуруу, Зүүн хоолой, Таацын цагаан нуур-нугын элс	Улсын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан Арц богд, Бага богдын нурууг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 04/05 дугаар тогтоолоор аймгийн тусгай хамгаалалтад авч, тухайн газарт мөрдөх дэглэмийг батлуулан хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. Хэрэгжилтийн хувь-100
6.АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ТУСГАГДСАН ЗААЛТЫН ХЭРЭГЖИЛТ					
6.1.	Аймгийн аялал жуулчлалын бүс нутгийн онцлогт тулгуурлан аялал жуулчлал эвент арга хэмжээнүүдийг зохион байгуулах, "ITM" ОУ-ын аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцох	-	Эвент арга хэмжээнүүдийг зохион байгуулсан эсэх	Уламжлал болон зохион байгуулагддаг эвент арга хэмжээнүүдийг зохион байгуулсан байна.	Байгаль орчин, аялал жуулчлалын яамны дэмжлэгтэйгээр аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Хужирт, Бат-Өлзий сумдын Засаг даргын Тамгын газар, аймгийн "Дэлхийн өв-Орхон голын нүүдэлчид" аялал жуулчлалын холбоо хамтран бүс нутгийн онцлогт тулгуурласан аялал жуулчлалын эвент арга хэмжээ "МОНГОЛ ЭСГИЙ УРЛАЛЫН БАЯР"-ыг Хужирт суманд 7 сарын 22-ны өдөр, "САРЛАГИЙН БАЯР"-ыг Бат-Өлзий суманд 2022 оны 07 сарын 23-ны өдөр тус тус зохион байгууллаа. Эвент арга хэмжээнүүдийг үзэж сонирхохоор Франц, Польш, Герман, Япон, Швейцар зэрэг орны жуулчид, дотоодын аялагчид нийт 1000 гаруй жуулчид үзэж сонирхлоо. "Ай Ти Эм-2022" олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцох бэлтгэл ажлыг аймгийн аялал жуулчлалын холбоотой хамтран зохион байгуулж, тус үзэсгэлэнд аймгийн нутаг дэвсгэрт аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг 20 аж ахуй нэгж, байгууллага оролцож, өөрсдийн үйл ажиллагаагаа сурталчилж, 2023 онд хамтран ажиллах гэрээ хэлэлцээрүүд хийгдсэн. Хэрэгжилтийн хувь-100
6.1.	Зочлох үйлчилгээний төрөлжсөн сургалт зохион байгуулах	-	-Сургалт зохион байгуулсан эсэх -Сургалтын үйл ажиллагаанд	Мэргэжлийн холбоодтой хамтран зохион байгуулсан байна.	-Зочлох үйлчилгээний төрөлжсөн сургалтыг орон нутгийн нөөц боломжид тулгуурлан зохион байгуулахаар төлөвлөж, аймгийн Политехникийн коллежтой хамтран аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлж байгаа нутгийн иргэдийг чадавхжуулах сургалтыг Бат-Өлзий суманд зохион

			хамрагдсан иргэдийн тоогоор		байгуулж, зочид буудлын үйлчилгээний ажилтны ангид Бат-Өлзий сумын 28 иргэн, аяллын хөтөчийн ангид Уянга сумын 25 иргэн тус тус хамрагдлаа. Аймгийн аялал жуулчлалын холбоотой хамтран “Хог хаягдлын менежментийг сайжруулах нь” сэдэвт зөвөлгөөнийг Хужирт суманд 2022 оны 04 сарын 04-нд зохион байгуулсан. Зөвлөгөөнд аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг иргэд, төрийн байгууллагуудын төлөөлөл 60 гаруй иргэд оролцсон. Зөвлөгөөнөөс гарсан зөвлөмжүүдийг нэгтгэн, жуулчны баазууд болон бусад үйлчилгээний газруудад хүргүүлж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хэрэгжилтийн хувь-100
6.2.	Тусгай хамгаалалттай газар нутгийн нөөцөд тулгуурлан эко аялал жуулчлалыг хөгжүүлэх	-	Эко аялал жуулчлал эрхлэгчдийн тоогоор	Эко аялал жуулчлал эрхлэгчдийн тоо өмнөх оноос нэмэгдүүлнэ.	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 37 дугаар тогтоолоор “Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэд баримтлах журам”-ыг шинэчлэн баталсан. 2022 оны байдлаар Уянга сумын Хүйсийн найман нуур орчим 16 өрх, Бат-Өлзий сумын Хүрхрээ, Хойд агуйт, Хустай, Төвхөн хийд орчимд 46 өрх, Бүрд сумын Элсэн тасархайд 4 өрх, Богд сумын Сэрвэн хайрханд 1 өрх нийт 67 өрх эко гэр ажиллуулж байгаа бөгөөд морин аяллын хөтчөөр 26 иргэн тус тус ажиллаж байна. Энэ нь өмнөх онтой харьцуулахад эко гэр ажиллуулж байгаа малчин өрхийн тоо Уянга сумын Хүйсийн найман нуур орчимд 6 өрх, Бат-Өлзий суманд 8 өрхөөр тус тус нэмэгдсэн байна. Эдгээр аялал жуулчлалын чилэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа нутгийн иргэдийг зочлох үйлчилгээний болон аяллын хөтчийн сургалтад хамрууллаа. Хэрэгжилтийн хувь-70
6.3.	Аймгийн аялал жуулчлалын дэд хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, батлуулах	-	Хөтөлбөрийг шинэчлэн баталсан эсэх	Аялал жуулчлалын дэд хөтөлбөрийг боловсруулж, аймгийн ИТХ-аар батлуулсан байна.	Аймгийн аялал жуулчлалын дэд хөтөлбөрийн шинэчлэн боловсруулж, батлуулахаар бэлтгэл ажил хийгдэж байна. Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулга хэлэлцэгдэж байгаатай холбогдуулан батлуулах ажлыг хойшлуулаад байна. Хэрэгжилтийн хувь-30
6.4.	Жуулчдын аюулгүй байдлыг хангах чиглэлээр дундын		Аюулгүй байдлын нөхцөл сайжирсан эсэх	Сурталчилгаа, олон нийтийг хамарсан	Аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа үйлчилгээний байгууллагуудын чанар стандартыг

	хамтын ажиллагааг сайжруулах	-		арга хэмжээг 2-оос доошгүй удаа зохион байгуулж, орон нутгийн байгаль орчны салбарын гадаад дотоодын жуулчдын аюулгүй байдлыг хангах түвшин ахисан байна.	сайжруулах зорилгоор тохирлын үнэлгээ хийх аймгийн ажлын хэсэг 2022 оны 6 сарын 30-наас 7 сарын 06-ны хооронд гэст хаус /гэр буудал/ 4, жуулчны бааз 26-г хамруулж, хүнсний аюулгүй байдал, галын аюулгүй байдал, жуулчны тав тухтай байдлыг хангах чиглэлээр мэргэжил арга зүйн зөвөлгөө өглөө. Ай Ти Эм-2022” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн худалдааны үеэр “Өвөрхангай аймгийн аялал жуулчлалын зочлох үйлчилгээний чанарыг сайжруулах нь” сэдэвт аймгийн зөвлөгөөнийг 2022 оны 10 дугаар сарын 27-ны өдөр Улаанбаатар хотод зохион байгуулж, аймгийн хэмжээнд аялал жуулчлал эрхлэгчдийн төлөөлөл 42 хүн оролцлоо. Зөвлөгөөнд зочин илтгэгчээр Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Аялал жуулчлалын бодлого зохицуулалтын газрын шинжээч Н.Болормаа, Монголын аялал жуулчлалын холбооны Орон нутгийн аялал жуулчлалын зохиоцуулагч Б.Буянбадрах, Зочлох үйлчилгээний сургагч багш Б.Халиун нар оролцож, орон нутгийн зочлох үйлчилгээний салбарт тулгамдаж олон асуудлын шийдэл болон боломжийг илтгэлүүдээр дамжуулан хүргэсэн. Хэрэгжилтийн хувь 100
6.5.	Аялал жуулчлалын асуудал хариуцсан хариуцсан мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалтад хамруулах	-	Сургалтад хамрагдсан тоо	БОАЖГ-ын аялал жуулчлалын асуудал хариуцсан мэргэжилтэн 2-оос сургалтад хамрагдсан байна.	Ай Ти Эм-2022 аялал жуулчлалын олон улсын үзэсгэлэнгийн үеэр 21 аймгийн аялал жуулчлалын асуудал хариуцсан мэргэжилтнүүдийн дунд зохион байгуулсан сургалт, аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсээс 2022 оны 09 сарын 22-нд зохион байгуулсан “Хэмжил зүйн суурь асуудлууд” сэдэвт сургалтуудад асуудал хариуцсан мэргэжилтнийг хамруулсан. Хэрэгжилтийн хувь 100
6.6.	Аялал жуулчлалын салбарын гадаад сурталчилгааг идэвхжүүлэх, цахимжуулах	-	Цахим мэдээллийн сан үүсгэсэн эсэх	Аймгийн аялал жуулчлалын мэдээллийн санг бий болгосон байна.	“Трэйвэлхаб” аялал жуулчлалын цахим мэдээллийн санд аймгийн аялал жуулчлалын байрших хэрэгслийн хүчин чадлын судалгаа, жуулчдын статистик мэдээлэл, үзмэр газруудын мэдээлэл, аялал жуулчлалын салбарын хүний нөөцийн судалгааг нэгтгэн байршуулж, аймгийн цахим мэдээллийн сангийн дата үүсгэлээ. Uvurkhangaitravel гар утасны аппликейшнаар дамжуулан дотоод, гадаад жуулчдад мэдээлэл сурталчилгааг өгч

					ажилласан. 2022 онд зохион байгуулсан эвентүүдийг Франц, Польш, Герман, Япон, Швейцар зэрэг орны жуулчид, дотоодын аялагчид нийт 1000 гаруй жуулчид үзэж сонирхсон. Мөн БОАЖЯамнаас Солонгос улстай аялал жуулчлалын чиглэлээр хамтран ажиллах хүрээнд Солонгосын үндэсний EBS телевизийн “Дэлхийгээр аялцгаая” нэвтрүүлгийн багийнхан тус аймагт эвентүүдийн үеэр ажиллаж, 2 удаагийн нэвтрүүлгийг бэлтгэн гаргаж, Солонгос улсад аймгийн аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчлах ажил хийгдсэн. Дээрх нэвтрүүлгийг youtube-д байршуулснаар 2 мянга гаруй иргэн үзэж сонирхсон байна. Хэрэгжилтийн хувь 100
7.УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙГ СААРУУЛАХ ДАСАН ЗОХИЦОХ					
7.1.	Оюутан сурагчид, олон нийтэд хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чиглэлээр мэдлэг, мэдээлэл олгох арга хэмжээ авч хэрэгжүүлэх	УТ	Зохион байгуулсан арга хэмжээний тоогоор	Аймгийн хэмжээнд уг чиглэлээр 3-аас доошгүй арга хэмжээг хэрэгжүүлж ажилласан байна.	-Жил бүр тогтмол зохион байгуулагддаг Ус цаг уурчдын баярын өдрийг тохиолдуулан Тэмүүлэл-Эрдэм сургуулийн сурагчдад усны чанар, хэрэглээний талаар мэдлэг олгох сургалт зохион байгуулсан. Улсын тэргүүний мэргэд сургуулийн 9-р ангийн сурагчид Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн үйл ажиллагаатай танилцаж аймгийн уур амьсгалын өөрчлөлт ирээдүйн хандлагын талаар мэдээлэл авлаа. Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн инженер техникийн ажилтнуудын дунд Эрдэм шинжилгээний баг байгуулж, илтгэл, сурталчилгааны материалыг 5 удаа бэлтгэсэн. Хэрэгжилтийн хувь-70
8. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ГҮЙЦЭТГҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ					
8.1.	Эрдэнэзуу музейн “Аялал жуулчлалын гудамж” төсөл /Өвөрхангай, Хархорин сум/	УТ	“Аялал жуулчлалын гудамж” төслийн ажлын гүйцэтгэлээр	“Аялал жуулчлал гудамж” төслийг ашиглалтад оруулж хүлээж авсан.	“Аялал жуулчлалын гудамж байгуулах” ажил 2022 оны 05 сарын 01-нд бүтээн байгуулалтын ажил эхэлсэн бөгөөд аймгийн Засаг даргаас томилогдсон ажлын хэсэг Хархорин суманд хийгдэж байгаа “Аялал жуулчлалын гудамж байгуулах” ажлын гүйцэтгэлд 3 удаа хяналт тавьж ажилласан. Уг ажлын хүрээнд Хархорин, Эрдэнэзуу музейг холбосон аялал жуулчлалын гудамж байгуулах 4 багц ажил хийгдэж байна. Одоогийн байдлаар “Цэвэр ус, ариутгах татуургын шугам сүлжээ, бохирын цооног” хийх багц ажлын хүрээнд 520 метр цэвэр усны шугам, 480 метр бохир усны

					шугам татах ажил, “Гадна цахилгаан хангамж, гэрэлтүүлэг” багц ажлаас 1500 метр агаарын шугам татаж, 04 кв-ийн дэд станцыг байршуулах, “Явган зам, гадна хайс, сүүдрэвч” багцын хүрээнд 1100 метр хайсан хашаа, явган замын газар шорооны ажил тус тус хийгдээд байна. “Авто зогсоол, эко хавтан” багц ажлын хүрээнд 28700 м2 хатуу хучилттай авто зогсоол, 3580 м2 эко хавтан зам баригдсан байна. Хэрэгжилтийн хувь-70
8.2.	Өвархангай аймгийн цөлжилт, газрын доройтолд өртсөн газарт хамгаалалтын ойн зурвас байгуулах	Гадаад эх үүсвэр	Хамгаалсан ойн зурвасын хэмжээ га	8 га талбайд ойн зурвас байгуулсан байна	-Улсын төсвийн 90,0 сая төгрөгийн санхүүжилтээр газрын доройтол, цөлжилтөөс сэргийлэх хөтөлбөрийн хүрээнд Баруунбаян-Улаан суманд 8 га хамгаалалтын ойн зурвас байгуулах ажлыг “Их сумт хайрхан” ХХКомпани гүйцэтгэлээ. Ойн зурваст хайлаас, загийн бортоготой тарьц 6800 ширхэгийг тарьсан нь намрын тооллогоор 85 хувийн амьдралттай тоологдлоо. БОАЖЯам болон аймгийн Засаг даргаас томилогдсон ажлын хэсэг газар дээр нь очиж ажлын гүйцэтгэлийг актаар хүлээн авсан. Хэрэгжилтийн хувь-100
8.3.	Ус цаг уур орчны шинжилгээний төвийн барилга /Хужирт сум/	УТ	Барилгын гүйцэтгэлээр	Зураг төсөв хийгдэж барилга баригдсан байна.	-Хужирт сумын Ус цаг уур орчны шинжилгээний төвийн барилгын ажлын тендер зарлагдаж “Сонор гуа” ХХК гүйцэтгэгчээр шалгарч 2022 оны 05-р сарын 1-ний өдрөөс барилгын ажил эхлэн 130 м2 талбай бүхий 10х6 хэмжээтэй, 5 өрөө, 2 давхар барилгын ажил улсын төсвийн 400 гаруй сая төгрөгөөр хугацаанаас нь өмнө гүйцэтгэн ашиглалтад оруулсан. Хэрэгжилтийн хувь-100
8.4.	Уур амьсгалын өөрчлөлтийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдийн ойлголт, чадавхыг бэхжүүлэх-сургалтад хамруулах	-	Сургалт, арга хэмжээний тоо Хамрагдсан байдал	Аймгийн уур амьсгалын өөрчлөлтийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдийн мэргэжлийн болон техникийн ур чадварыг сайжруулах, мэдлэг олгосон байна.	-БОАЖЯамнаас 2022 оны 04 дүгээр сарын 05-07-ны өдрүүдэд Парисын хэлэлцээрийн ил тод байдлын тогтолцоо ба үндэсний тодорхойлсон хувь нэмрийн хүрээнд орон нутгийн мэргэжлийн байгууллагуудын албан хаагчдын уур амьсгалын асуудалтай холбоотой шийдвэр гаргалтын чадавхыг дээшлүүлэх сургалтад ЗДТГ-ын мэргэжилтэн, УЦУОШАлбаны инженер, Төрийн сан, БОАЖГазрын мэргэжилтнүүд тус тус хамрагдсан. Аймгийн ИТХурал, аймгийн ТББ-уудын холбооноос зохион байгуулсан “Гурван талт түншлэлийн оролцоотой уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг бууруулах нь” сэдэвт сургалтад Байгаль

					орчин, аялал жуулчлалын газрын дарга, мэргэжилтнүүд хамрагдлаа. Хэрэгжилтийн хувь-100
	Хэрэгжилтийн дундаж үнэлгээ				92,9

ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ ТАЙЛАГНАСАН

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГА

Г.БАЯСГАЛАН

ХЯНАСАН

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

А.ИШДОРЖ

-оОо-